



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 08 сарын 16 өдөр

Дугаар АБЧЗ

Улаанбаатар хот

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацийн үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгал"-ын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга:

Э.Төрбаяр  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын  
навигацийн үйлчилгээний газрын дарга)

Гишүүд:

Н.Баярмаа  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү,  
эдийн засаг төлөвлөлтийн газрын ерөнхий  
нягтлан бодогч)

А.Энхцэцэг  
(“Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл”  
Төрийн бус байгууллагын гишүүн  
(тохиролцсоноор))

О.Баярсайхан  
(“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”  
Төрийн бус байгууллагын гишүүн  
(тохиролцсоноор))

Нарийн бичгийн  
дарга:

Э.Энхжин  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Худалдан  
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Э.Төрбаяр)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт

тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Энхжин)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА